

# ТОВЧ ЗААВАР

## Өдөр бүр судраас суралцах зорилго



### ЭНЭ ЖИЛ ШИНЭЭР ЮУ НЭМЭГДСЭН БЭ?

2021.01.01-ээс эхлэн хичээлийн кредит үнэлгээ авахыг хүсэж буй семинарын суралцагчид суралцах явцдаа тухайн хичээлийн улирлын хуанлийн хоногийн 75-аас доошгүй хувьд судар унших шаардлагатай болно. (Журмын гарын авлага дахь “Хичээлийн гүйцэтгэл ба төгсөлтөд тавигдах судар унших шаардлага” хэсгийг үзнэ үү). Өдөр бүр судраас суралцах зорилго тавьж, үүнийгээ тогтмол хэрэгжүүлэхэд нь суралцагчдыг дэмжих замаар багш нар тэдэнд уг шаардлагыг биелүүлэхэд тусалж чадна.



### ӨДӨР БҮР СУДРААС СУДЛАХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “Бид Есүс Христийн шавь байхыг эрэлхийлэх үед, Түүнийг сонсох бидний хүчин чармайлт ямагт зорилготой байх хэрэгтэй. Өдөр бүр амьдралаа Түүний үгс, сургаал, үнэнээр дүүргэх нь ухамсартайгаар тууштай чармайхыг шаарддаг. . . . Өдөр бүр Бурханы үгэнд шимтэх нь гэнэтийн тогтворгүй байдал өсөн нэмэгдэж буй энэ өдрүүдэд сүнслэг байдлын хувьд амьд гарахад нэн чухал. Өдөр бүр Христийн үгэн дээр найрлавал, Христийн үгс бидэнд хэзээ ч төсөөлж байгаагүй саад бэрхшээлтэй тулгарах үедээ юу хийхийг хэлж өгөх болно” хэмээн заасан (“Түүнийг сонс,” 2020 оны 4-р сарын Ерөнхий чуулган).



### ТА СУРАЛЦАГЧДАДАА ХЭРХЭН ТУСАЛЖ ЧАДАХ ВЭ?

Багш нар хичээлийн улирал бүрд судраас утга учиртай суралцах туршлагыг бүрдүүлэх замаар суралцагчдадаа тусалж чадна. Хичээлийн шинэ жил бүрийн эхэнд багш нар суралцагчдад судар уншихын ач холбогдлыг мөн тэднийг Аврагч Есүс Христэд илүү ойртуулах судруудын хүч чадлын талаар хэлэлцэх цагийг гаргаж өгөх хэрэгтэй. Өдөр бүр судраас суралцах зорилгыг өөртөө тавихад суралцагчдыг урамшуулах нь зүйтэй.

Багш нар суралцагчдыг өдөр бүр бие даан судраас суралцах зорилгоо гүйцэлдүүлэхэд нь туслахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Багш нар энэхүү үүргээ олон янзаар биелүүлж болно. Үүнд:

- Шавь байх өөрсдийнх нь замналд төдийгүй Есүс Христэд хөрвөгдөхийн тулд өдөр бүр судраас суралцахын ач холбогдлыг ойлгоход суралцагчдад туслахын тулд судрууд болон орчин цагийн бошиглогчдын сургаалыг ашигла.
- Өдөр бүр судраас суралцах зорилгыг, тухайлбал өөрсдийнх нь хэрэгцээ, чадамжид таарсан, тохиромжтой бөгөөд утга учир бүхий зорилго тавихад нь суралцагчдад тусал.
- Суралцагчдыг таньж мэдэн, тэдний судраас суралцах туршлагыг тогтмол эргэн шалга.
- Судраас бие даан суралцсанаар Есүс Христийн тухай болон Түүний сайн мэдээний талаар юу сурч, мэдэрч байгаагаа хичээл дээр гэрчлэх тогтмол боломжоор суралцагчдыг ханга.

- Өдөр тутмын хувийн судрын уншлагаа mySeminary аппликэйшн дээр хөтлөх мөн бусад тэмдэглэх аргыг ашиглах боломжийг ангид бүрдүүлснээр суралцагчдад хариуцлагатай байхад нь байнга тусал.
- Хэрэв суралцагчид судраа 75-аас доош хувьтай уншсан бол судар уншихыг урамшуулан дэмжих замаар тэдэнд тусал.



## **БАГШ НАРЫН АШИГЛАХ БОЛОМЖТОЙ ЭХ СУРВАЛЖУУД**

- Бүх багшийг бүрэн цагийн удирдагч нь тогтмол эсвэл сар тутмын хэлэлцүүлгээр дамжуулан сургах ёстой. Энэ сургалтыг орон нутагт тохируулан өөрчлөх талаар бүс нутгийн захиралтай зөвлөлдөн шийдэх нь зүйтэй.
- MySeminary аппликэйшн дээр өдөр тутмын судрын уншлагаа тэмдэглэж, хөтлөхөд нь суралцагчдад туслах зөвлөгөөг <https://web.microsoftstream.com/channel/8600711f-29ec-40c8-99d2-c1240a7204ec>. холбоосоор орж харна уу.
- MySeminary аппликэйшныг ашиглах боломжгүй бүсүүдэд орон нутгийн зохицуулалт хийж болно.
- Журмын гарын авлагын “Нөхөж хийх” хэсэг дэх зарчмуудыг судрын уншлага нь 75-аас доош хувьтай байгаа суралцагчдад туслахад ашиглана. Судар уншлагын бүрэлдэхүүн хэсгийн жишээнүүдийг дээр дурдсан сургалтын тоймоос олж болно.

